

УС БА БАЙГАЛЬ



НУБ-ын УС

ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР

2018 оны 3 сарын 22



АГУУЛГА

1

Ус байгальд орших байдал

2

Усны нөөц

3

Усны ашиглалт, хэрэглээ

4

Ус ба байгаль

5

Усны бохирдол

6

Дүгнэлт

Дэлхийн усны өдөр 2018




NATURE FOR WATER: WORLD WATER DAY 2018

Нэгдсэн үндэсний байгууллагаас жил бүрийн **3 дугаар сарын 22-ны** өдрийг "**ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР**" болгон тэмдэглэж байхаар тунхагласан. 2018 оныг дэлхий нийтээрээ "**Ус ба байгаль**" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр зарласан.

<http://worldwaterday.org/>

Усны төлөв, байдал



Цэнгэг ус хэвийн даралттай үед $+100^{\circ}\text{C}$ -д буцалж, 0°C -д хөлдөх ба 4°C (3.98°C) температуртай үедээ хамгийн их нягттай байдаг.

Ус - Байгаль



1. Гадаргын ус


- Гол, горхи
- Нуур, цөөрөм
- Далай, тэнгис
- Мөнх цас, мөстөл, мөсөн гол



2. Газрын доорх ус

Газрын гадаргын доор байгаа ус (хөрсний ус, гүний ус)....

ДЭЛХИЙН УСНЫ НӨӨЦ



Дэлхийн нийт
усны нөөц 1386
сая км³/жил




Үүнээс



Цэвэр ус 1%

Мөс 2%



Далай тэнгисийн
давстай ус 97%

Ус нь хүний амьдралын амин чухал хэрэглээ, юугаар ч орлуулшгүй чандмань эрдэнэ билээ. Түүний үнэт чанар нь химийн аргаар гарган авч болдоггүйд оршино. Дэлхий дээр байгаа нийт усны **1 хувь нь** цэвэр ус байдаг. Цэвэр усны нөөцийн асуудал хүн ам ихээр суурьшсан томоохон хотуудын хамгийн гол санаа зовоосон асуудлуудын нэг болоод байна.

Монгол орны усны нөөц

Монгол орны усны нийт нөөц
 $608\text{км}^3/\text{жил}$



Гадаргын ус 70%
Газрын гүний ус 30%
эзэлдэг.

Монгол орны усны нөөц

Нийт усны нөөцийн 70% гадаргын ус эзэлдэг.



83,7% нуурын ус



10,5% мөстөл, мөсөн гол




5,8% гол, мөрөн



Манай орны гол мөрний 60% нь хил даван урсдаг бол 40% нь хөрсөнд нэвчин газрын доорх гүний усыг тэжээдэг байна.

Гадаргын усны 83% нь цэнгэг ус ба нийт цэнгэг усны 93,6% -ийг Хөвсгөл нуур эзэлдэг.

Монгол орны усны сав газар



Нийт 29 сав газартай

Таних тэмдэг

- улсын хил
- аймгийн хил
- аймгийн төв
- нуур
- гол

Усны сав газар

- 1, Сэлэнгэ
- 2, Хөвсгөл нуур-Эг
- 3, Шишхэд
- 4, Дэлгэрмөрөн

- 5, Идэр
- 6, Чулуут
- 7, Хануй
- 8, Орхон
- 9, Туул
- 10, Хараа
- 11, Ерөө



- 12, Онон
- 13, Улз
- 14, Хэрлэн
- 15, Буйр нуур-Халх
- 16, Мэнэнгийн тал
- 17, Умард говийн гүвээт-Халхын дундад тал
- 18, Галба-Өөш-Долоодын говь

- 19, Онги
- 20, Алтайн өвөр говь
- 21, Таац
- 22, Орог нуур-Түй
- 23, Бөөнцагаан нуур-Байдраг
- 24, Хяргас нуур-Завхан
- 25, Хүйсийн говь-Цэцэг нуур


- 26, Үенч-Бодонч
- 27, Булган
- 28, Хар нуур-Ховд
- 29, Увс нуур-Тэс

Усны сав газар

Усны сав газар гэж гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зай юм.



ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗАР




Туул голын сав газар нь Улаанбаатар хотын 7 дүүрэг, 5 аймгийн 37 сумын нутаг дэвсгэрийг хамардаг бөгөөд нийт 1,4 сая хүн ам, 4,3 сая малыг усаар хангадаг. Туул гол нийт 717 км урсаж Орхон голд цутгадаг.

Усны хэрэглээ - ашиглалт




Хүний өдөр тутмын амьдралдаа хэрэглэж буй ус

Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад хэрэглэж буй ус




Усны хэрэглээ - ашиглалт


Дэлхийн ус ашиглалт



Монгол орны ус ашиглалт



Ус хэрхэн яаж та бүхэнд хүрдэг вэ?



Манай орон, хязгаарлагдмал нөөц болох газрын гүний цэвэр цэнгэг усыг хүн амын унд ахуй, эрчим хүч, дулаан хангамж, барилга, зам талбай, ногоон байгууламжийн усалгаа, машин угаалга гээд бүхий л хэрэгцээндээ ашигладаг.

Усны зохистой хэрэглээ



Ус хэмнэнэ гэдэг нь унд, ахуйн усны хэрэглээгээ бууруулах биш усыг сул асгахгүй, усны цоргыг онгорхой орхихгүй, эвдэрсэн тоног төхөөрөмжийг цаг тухайд нь засварлахыг хэлнэ.

Та бүхний худалдан авч буй усны дусал бүхэн танд үр шимээ өгч байх нь чухал. Жишээ нь та ванн дүүрэн усанд орж, тэндээс сэтгэл ханамж авсан бол тэр ус үргүй асгаагүй, үр шимээ өгсөн гэсэн үг юм.



Усны эргэлт

Усны эргэлт алдагдсанаар байгаль экологийн тэнцвэргүй байдал үүсч дараах сөрөг үзэгдлүүд гарч байна.

Монгол улсын хэмжээнд 2007 оны усны тооллогоор


- 5128 гол горхи урсдаг байснаас 852 нь,
- 9306 булаг шандын 2277 нь,
- 7474 нуур цөөрмийн 1181 нь,
- 429 рашаан усны 60 нь ширгэж үгүй болсон байна.
- Гүний усны түвшин 3-5 метр доошилсон,
- Мөнх цаст уулын 40% хайлсан,

Өөрөөр хэлбэл нийт гол мөрний 16%, булаг шандын 21,8%, нуур тойрмын 28 % нь ширгэж үгүй болсон гэсэн гунигтай мэдээ байна.



Ус ба байгалийн эргэх, мөчлөг

Нарны хурц тусгал нь далай, тэнгисийн усыг халааж ууршуулдаг. Уур нь агаар мандалд дэгдэж, эргээд цас бороо болж байгаль дэлхийг усалдаг. Үүнийг усны мөчлөг буюу усны эргэлт гэдэг. Цас бороо нь мод, ургамал, цэцэгс, ногоон байгууламжийг усалж ургуулдаг ба хөрсийг чийгшүүлж, рашаан булаг ундарч гол мөрний эх болдог байна. Энэ нь байгалийн эргэх холбоо юм.



Ус ба байгаль

Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж байгалийн баялаг ой мод байсан газар хожуул болон үлдсэн байна.

Энэ ойд амьдарч байсан ан амьтад дайжин, ургамал, цэцэгс хатаж, дахин сэргэхээргүй болсон байна.

Ингэж байгалийг сүйтгэсний улмаас хуурайшилт ихэсч, гол, горхи усны эх тасардаг.

Ой модны экологийн ач холбогдол нь ус цуглуулах, усыг жигд хуваарилах, тунадасыг нэмэх зэргээр усны горимыг зохицуулдаг.



Байгаль эхийг хайрлан хамгаалцгаая

Ойн хөрсний гадаргуу дээрх өвслөг ургамал, хүлэр ба ялзмагт давхраа, хагд өвс, хөвд, бут сөөг, ой мод галд их хэмжээгээр шатаж тархахыг ОЙН ТҮЙМЭР гэнэ.

Ой хээрийн түймрийн 90% нь хүний буруутай үйлдлээс гардаг. Жил бүрийн 3 сарын 20-оос 6 сарын 10-ны өдөр, 10 сарын 20-оос 11 сарын 10-ны өдөр хүртэл түймрийн аюултай үе юм. Иймд хуурайшилт ихтэй энэ үед ойд зугаалахгүй байх хэрэгтэй.




Ус ба байгаль

Түймэрт өртсөн ой мод дахин хэзээ ч сэргэхгүй.

Ойн түймрээс шалтгаалж гол горхи, булаг шандны усаар тэжээгддэг хээрийн болон говийн экосистем хуурайшиж, усны эргэлтийн горим алдагдан уур амьсгалын өөрчлөлтөд хүргэдэг.

Ус нь газрын гадаргын гол бүтээгч нь бөгөөд манай гаригийн уур амьсгалыг хянахын зэрэгцээ биднийг хүнсээр болон асар их энергээр хангадаг юм.




Усны бохирдол



Усны бохирдол



Том хэмжээний усан онгоцноос хаягдаж буй хаягдлууд болох бактер, эмнэлгийн хог хаягдал, тос, хүнд метал, угаалгын нунтаг зэрэг нь усан дахь амьдралыг хордуулах гол шалтгаан болж байна.



Хүний буруутай үйл ажиллагаа, усны бохирдлоос шалтгаалан Байжи дэлфин /Голын бурхан гэж нэрлэгддэг/ нь 2006 онд устаж үгүй болсон байна.

Усны бохирдол



Химийн үйлдвэрүүдийн утаа нь агаарт дэгдсэнээр агаар мандалд байгаа ус нь тодорхой химийн бодисууд /нүүрс хүчлийн хий, хүхэрлэг хий гэх мэт/-тай холилдоход маш хүчиллэг нэгдлүүд үүсдэг.

Хүчиллэг бороо нь экосистемд, ялангуяа усны экосистемд олон сөрөг үр дагавартай. Усан орчны баланс өөрчлөгдсөнөөр олон тооны усны амьтан, ургамал устаж, экосистемийн тэнцвэрийг алдагдуулдаг.

Усны бохирдол



Гол мөрөнд ус, ундааны сав, хаяснаас жилд 1 сая гаруй шувуу болон хөхтөн амьтан пластик хог хаягдлын нөлөөнд өртөж, устаж үгүй болж байна.



Фермерүүдийн хэрэглэж буй химийн гаралтай бордоо нь дэлхий даяар 400 орчим үхлийн бүсийг үүсгэж, ойр орчмын амьтан ургамлуудыг устаж үгүй болгоход хүргэж байна.

Усны хомсдол үүсэх шалтгаан

Дэлхийн дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлт, хэт халалт.

Цөлжилт, хуурайшилт, элсний нүүдэл,



Усны хомсдол үүсэх шалтгаан



Хотжилт, үйлдвэржилт, хүн амын эрчимтэй өсөлтөөс шалтгаалж агаарын болон хөрсний бохирдол,

Хүний буруутай үйл ажиллагаанаас хамааралтай, түймэр, ой модны зүй бус хэрэглээ, байгаль орчны тэнцвэрийг алдагдуулах,




Усны хомсдол үүсэх шалтгаан



Уул уурхайн олборлолт хийсний дараа нөхөн сэргээлт хийдэггүй.

Гадаргын болон гүний усны тэжээгдлийн мужид хууль бус ашигт малтмал, хайрга олборлох, гол горхи болон гадаргын усыг ахуйн бохирдлоор бохирдуулж буй үйлдлүүд юм.

A group of diverse cartoon children of various ethnicities and ages are holding hands in a circle around a stylized globe. The globe is light blue and white, showing continents and oceans. The children are smiling and looking towards the center. The background is white with blue wavy patterns on the sides, suggesting water or a sky. The overall theme is global unity and environmental care.

**Иймд ирээдүй болсон
хүүхдүүд та бүхэн эх дэлхий,
байгалиа хайрлан, усыг зүй
зохистой хэрэглэхийг
уриалж байна.**

**Ус чандмань эрдэнэ
Тус зэндмэнэ эрдэнэ**



Хамтран зохион байгуулсан байгууллагууддаа БАЯРЛАЛАА

Анхаарлаа хандуулсанд БАЯРЛАЛАА

